



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/01

Баянхошуу

Орон тоо, цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай 13 дугаар тогтоол, 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоол, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 тогтоолын 3, 6, 9, 11 дүгээр хавсралтууд, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 15/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарын цалин, нэмэгдэл хөлсийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсөв, цалингийн санд багтаан албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалинг бодож олгохыг нягтлан бодогч (Ц.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Анхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642301197

Сумын Засаг даргын...*Бал*... оны ...*01*... дүгээр сарын
08... ны өдрийн...*А/д*... дүгээр захирамжийн хавсралт

№	Албан тушаалын нэр	Нэр	Цалингийн шатлал	Үндсэн цалин	Алба хаасан хугацааны нэмэгдэл хувь	Алба хаасан хугацааны нэмэгдэл	Онцгой нэмэгдэл хувь	Онцгой нэмэгдэл хувь	Орон нутагт ажилласны нэмэгдэл хувь	Орон нутагт ажилласны нэмэгдэл	Нууцны нэмэгдэл хувь	Нууцны нэмэгдэл	ЭБТ-ны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажилтны нэмэгдэл хувь	ЭБТ-ны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажилтны нэмэгдэл
1	Засаг даргын орлогч	Д.Батболд	УТ	1,700,000	20%	319,400	30%	510,000	60%	958,200	10%	159,700	20%	319,400
2	Тамгын газрын дарга	Ж.Алтантуяа	Т3-5	1,597,000	20%									
3	Багийн засаг дарга	Г.Мөнхбаясгалан	УТ	1,250,000			30%	375,000						
4	Багийн засаг дарга	Б.Жамбалцанжид	УТ	1,250,000			30%	375,000						
5	Багийн засаг дарга	Ц.Нанжидсүрэн	УТ	1,250,000			30%	375,000						
6	Багийн засаг дарга	Д.Болдбаатар	УТ	1,250,000			30%	375,000						
7	Багийн засаг дарга	Ч.Түмэнжаргал	УТ	1,250,000			30%	375,000						
8	Багийн засаг дарга	М.Дүүрэнжаргал	УТ	1,250,000			30%	375,000						



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 1/02

Баянхошуу

Галуут сумын 2024 оны "Цэргийн
бүртгэл"-ийг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Батлан хамгаалахын сайдын "Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай" 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.6.1, 3.3 дахь хэсэг, Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/682 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2024 оны Цэргийн бүртгэлийг 01 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Алтантуяа	(Тамгын газрын дарга)
Гишүүд	О.Нэмэхбаяр	(Хэсгийн төлөөлөгч)
	Б.Анхбаяр	(Санхүүгийн албаны дарга)
	Ц.Ганчөдөр	(Улсын бүртгэгч)
	Ж.Ганчулуун	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
	М.Мандах	(Татварын Улсын байцаагч)
	Л.Эрдэнэчимэг	(Архив, бичиг хэргийн эрхлэгч)
	Э.Ганболд	(Цахим үйлчилгээ хариуцсан ажилтан)
	Г.Мөнхбаясгалан	(Хайрхан багийн Засаг дарга)
	Б.Жамбалцанжид	(Сүмбэр багийн Засаг дарга)
	Ц.Нанжидсүрэн	(Үнэгт багийн Засаг дарга)
	Д.Болдбаатар	(Баяннуур багийн Засаг дарга)
	Ч.Түмэнжаргал	(Мандал багийн Засаг дарга)
	М.Дүүрэнжаргал	(Баянхошуу багийн Засаг дарга)

2.Цэргийн бүртгэлийн үеэр нийгмийн хэв журам сахиулах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч (О.Нэмэхбаяр)-д үүрэг болгосугай.

642301199

3.Цэргийн бүртгэлээр шаардлагатай тоо мэдээ, судалгааг гаргаж хамтран ажиллахыг Улсын бүртгэгч Ц.Ганчөдөр, Санхүүгийн албаны дарга Б.Анхбаяр, Татварын Улсын байцаагч М.Мандах нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тухайн онд 18 нас хүрч байгаа 2006 онд төрсөн иргэнийг цэргийн бүртгэл явагдах байранд өөрийн биеэр ирж бүртгэлд хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Цэргийн бүртгэл явуулах, мэдээ тайлан хүлээлгэн өгөхөд шаардлагатай зардлыг Засаг даргын Тамгын газрын төсвөөс холбогдох баримт материалыг үндэслэн зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

6.Цэргийн бүртгэлийн ирцийг хангалттай хүргэх, цэргийн насны залуусын идэвх оролцоог сайжруулах үүднээс Малчдын дунд зохион байгуулагддаг волейболын тэмцээнийг удирдамж гарган явуулахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ж.Ганчулуун)-д даалгасугай.

7.E-Mongol цахим бүртгэлийн талаар бичлэгийг сумын зарын нэгдсэн групп болон цэргийн бүртгэл явуулах байрандаа зурагт байрлуулан байнга тоглуулах, иргэдийг өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаараас бүртгүүлэх талаар мэдээлэл хүргүүлэх, хэрэв бүртгүүлэх явцад алдаа гарч ямар нэг байдлаар саад учирсан тохиолдолд асуудлыг шийдвэрлэхийг цахим үйлчилгээ хариуцсан оператор (Э.Ганболд)-д даалгасугай.

8.Цэргийн насны залуучууд болон 17 настай залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, шаардлагатай бол эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах, бүртгэлд хамрагдаж байгаа иргэдэд эрүүл мэндийн сургалт мэдээлэл хүргэж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ундармаа)-д үүрэг болгосугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сумын 2024 оны Цэргийн бүртгэлийг тогтоосон хугацаанд хуулийн дагуу зохион байгуулж, иргэдэд батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчилах, бүртгэлийг сумын цэргийн бүртгэлийн мэдээллийн санг түшиглэн явуулах, иргэний мэдээллийг тодотгон баяжилт хийх, шинээр бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдэд хөтлөгдөх маягт, хүснэгтүүдийг үнэн зөв бүрэн хөтлөх, өдөр тутмын мэдээг тогтоосон хугацаанд цэргийн штабт утсаар өгч ажиллахын зэрэгцээ эцсийн дүн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд аймгийн цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (Ж.Алтантуяа)-д даалгасугай.

ОРЛОГЧ



Д.БАТБОЛД



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 4/03

Баянхошуу

Г Цаг үеийн нөхцөл байдлын талаар Г
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Аймгийн Засаг даргын 2024 оны А/27 дугаар захирамж, сумын онцгой комиссын 2024 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор дараах ажил арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг баг, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль болон Аймгийн онцгой комиссоос өгч буй үүрэг даалгаварыг тухай бүр хэрэгжүүлж ажиллах шуурхай штабын үйл ажиллагааг тогтмолжуулах цаг үеийн мэдээ мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг шуурхай Штабын дарга Д.Батболд-д

1.2. Төрийн албан хаагч болон иргэдэд байршил тогтоох 3 үгт хаягийг суулгуулах ажлыг зохион байгуулж, мэдээг 7 хоног бүрийн 5 дахь өдөр зургаар баталгаажуулан илтгэх хуудсаар шуурхай штаб (Д.Батболд)-д ирүүлж байхыг баг, байгууллагын дарга, эрхлэгч, Цагдаагийн хэсгийн төлөөлөгч О.Нэмэхбаяр нарт

1.3. Дулаан үйлдвэрлэлийг хэвийн хангаж түлшний нөөцийн бүрдүүлэлтийг тогтмол хийж, цахилгаан эх үүсвэрийн бэлэн байдлыг хангаж, мэдээллийг өдөр бүр шуурхай штаб (Д.Батболд)-д ирүүлж ажиллахыг Эко дулаан ХХК-д

1.4. Малчид мал бүхий иргэдтэй “Хариуцлагын гэрээ”-г байгуулах ажлыг эрчимжүүлэх өрхийн утасны жагсаалтыг тогтмол шинэчлэх, шаардлагатай үед холбоо барих утасны дугаарын мэдээллийг нэмэлтээр гарган шуурхай штаб (Д.Батболд)-д ирүүлэх болон цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг тогтмол авч малчид, иргэдэд тухай бүр шуурхай хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт

642401001


1.5.Улирлын хичээл эхлэхтэй холбогдуулан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн хүүхдүүдийг заавал эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэн өгөх, амралтын өдрүүдэд дотуур байрны хүүхдүүд болон сумын төвийн айлд, өөрийн гэрээр амьдарч буй хүүхдүүдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (С.Цэгмид), Цэцэрлэгийн эрхлэгч (Б.Сайнзаяа), Багийн Засаг дарга нарт


1.6.Цаг агаарын аюулт үзэгдэл үүссэн үед иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн ахлах дэслэгч (О.Нэмэхбаяр)-д

1.7.Сумын төвийн дэлгүүрүүдэд стандартыг мөрдүүлэх, бараа бүтээгдэхүүний үнэ ханш, чанар, нийлүүлэлтийн байдалд хяналт шалгалт хийж хүнсний бүтээгдэхүүний нөөцийг 50 хувиас доошгүй байхаар бэлэн байдлыг хангаж ажиллах үүрэг даалгавар өгч, биелэлтийг илтгэх хуудсаар ирүүлэхийг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Э.Сувд-Эрдэнэ)-д

2.Холбогдох зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа), нягтлан бодогч (Ц.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд биелэлтийг тооцон үр дүнг сумын Онцгой комисст мэдээллэхийг Штабын дарга, Засаг даргын орлогч (Д.Батболд)-д даалгасугай.

ДАРГА  А.БАТБАЯР





**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/05

Баянхошуу

Г Газар өмчлөх захирамжийн хавсралтад
өөрчлөлт оруулах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар өмчлөх эрхийн гэрчилгээг шинэчлэн авах хүсэлтээ ирүүлсэн Сүмбэр 2 дугаар багийн иргэн Батжаргал овогтой Гончигсумлаад газрын хэмжээ, газрын байршлын хаяг, нэгж талбарын дугаарыг хавсралтад зааснаар тус тус шинэчлэн тогтоож шийдвэрлэсүгэй.

2.Иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрыг өмчлөх эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (А.Түмэннаст)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401005

Сумын Засаг даргын *2024* оны *01* дүгээр сарын *31*-ний өдрийн *1/8* дугаар захирамжийн хавсралт



ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

№	Газар өмчлөгчийн		Өмнөх захирамжийн		Өмнөх захирамжийн нэгж талбарын мэдээлэл		Шинээр үүссэн нэгж талбарын мэдээлэл				
	Овог нэр	Регистрийн дугаар	Огноо	дугаар	Хавсралтын мөрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Хаяг	Талбарын хэмжээ м ²	Нэгж талбарын дугаар	Хаяг	Талбарын хэмжээ м ²
1	Батжаргал Гончигсумлаа	BK75121114	2011.12.03	74	5	6411000087	Баянхошуу 6 дугаар баг, Баянхошуу 2-р хороо, 5-8 тоот	532	6411000087	Баянхошуу 6 дугаар баг, Хонгорхайрхан 5, 514 тоот	549

.....ооо.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 7/06

Баянхошуу

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын аварга малчин шалгаруулах журмын дагуу Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн “Сумын аварга малчин өрх”-өөр шалгаруулсан малчин өрхүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, “Сумын хөдөлмөрийн аварга”-аар шалгарсан албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аварга малчид, хөдөлмөрийн аврагуудын шагналд 4,500,000 (Дөрвөн сая таван зуун мянган) төгрөг зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

3.Төсвийн зарцуулалтанд хяналт тавьж, хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Б.Анхбаяр)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401007



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/07

Баянхошуу


“Хөх дөл” төслийг дэмжихэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нүүдэлчин ард түмний Монгол ахуй, Монгол аж төрөх ёсон, Үндэсний нэгдмэл үнэт зүйлсээр бахархах үзлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор нүүдэлчин амьдралын хэмнэл дор, 4 улирлын элдэв араншинг аялдан даган ажиллаж, амьдарч буй залуу гэр бүлийн дэлгэцийн бүтээлийг хийж, олон нийтэд хүргэх “Хөх дөл” төслийг санаачлагчдаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх үүднээс сумын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Үндэсний өв соёл болох цагаан сарын баярын хөтөлбөрт арга хэмжээний зураг авалтын үйл ажиллагаанд 3,000,000 (Гурван сая) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа)-д даалгасугай.

ДАРГА  А.БАТБАЯР

642401009



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 7/08

Баянхошуу

Г Сар шинийн нэгдсэн золголтод
хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.3, 7.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд зохион байгуулах сар шинийн нэгдсэн золголтын арга хэмжээнд 1,200,000 (Нэг сая хоёр зуун мянган) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардлагатай санхүүжилтийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

3.Нэгдсэн золголтын бэлтгэл ажлыг сайтар хангаж, зохион байгуулалттай, ёслол төгөлдөр хийж гүйцэтгэхийг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401011



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/09

Баянхошуу

Сар шинийн баяраар эргүүл
жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн баяраар 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийг дуустал ажиллах сумын нэгдсэн эргүүл жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Байгууллага бүр сар шинийн баярын өдрүүдэд гадна талбайгаа гэрэлтүүлэгтэй байлгах, байрны харуул хамгаалалтад хяналт тавьж, жижүүрүүдийн ажлын хариуцлагыг сайжруулахыг дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3.Сар шинийн баярын амралтын өдрүүдэд цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол өгч байхыг Ус цаг уурын өртөөний эрхлэгч (Х.Дүүрэнхундага)-д, байгууллагуудын халаалт дулааныг хэвийн байлгах, ээлжийн ажилтнуудыг илүү хариуцлагажуулж ажиллахыг ЭКО Дулаан ХХК-ний захирал (О.Хүрэлхуяг)-т, Эргүүл жижүүрт шаардагдах шатахууныг шийдвэрлэхийг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Эргүүл жижүүрийг удирдлагаар хангаж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ Захирамжийн хэрэгжилтийг 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулахыг Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн ахлах дэслэгч (О.Нэмэхбаяр)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401013

Сумын Засаг даргын *2024* оны *02* дугаар
сарын *09*-ны өдрийн... *А/09* дугаар
захирамжийн хавсралт

ЭРГҮҮЛ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

д/д	Жижүүр хийх өдөр	Жижүүрт ажиллах ажилтнууд	Ажиллах цаг	Жижүүрт ажиллах ажилтнуудын утасны дугаар	Хяналт тавих албан тушаалтны нэр
1	2024.02.09	Г.Мөнхбаясгалан	18 ⁰⁰ -21 ⁰⁰	89494142	Хэсгийн төлөөлөгч Ц/д.О.Нэмэхбаяр
2		А.Түмэннаст	21 ⁰⁰ -01 ⁰⁰	99447178	
		А.Тамир		88041619	
		Б.Жамбалцанжид		80121247	
3	2024.02.10	Ц.Ганчөдөр	18 ⁰⁰ -21 ⁰⁰	88838596	Хэсгийн цагдаа, Ц/а.а Г.Сүхцэрэн
4		Ц.Нанжидсүрэн	21 ⁰⁰ -01 ⁰⁰	89596363	
		С.Цэгмид		88857919	
		Б.Анхбаяр		89279566	
5	2024.02.11	Э.Ганболд	18 ⁰⁰ -21 ⁰⁰	88696867	Олон нийтийн цагдаа Э.Эрхэмбаяр
6		Б.Гомбодорж	21 ⁰⁰ -01 ⁰⁰	80448090	
		М.Отгондалай		88930813	
		Б.Ундармаа		88737746	
7	2024.02.12	Ч.Түмэнжаргал	18 ⁰⁰ -21 ⁰⁰	99443839	Хэсгийн цагдаа, Ц/а.а Г.Сүхцэрэн
8		М.Баяртогтох	21 ⁰⁰ -01 ⁰⁰	80127667	
		Д.Болдбаатар		86556668	
		Б.Сайнзаяа		88382920	

-----0-----



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар #10

Баянхошуу

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам батлах тухай 86 дугаар тушаалын 3.4.4, 4.5.9, Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/27 тоот захирамж, аймгийн Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр сарын 19, сумын Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын гэрээг байгуулж 72.000.000 (Далан хоёр сая) төгрөг зарцуулсугай.

2.Өвс, тэжээлийн үнийг байгуулсан гэрээг үндэслэн тухай бүр Орон нутгийн хөгжлийн сангийн өвс, тэжээлийн зардлаас зарцуулахыг Орон нутаг хариуцсан нягтлан бодогч (М.Отгондалай)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Анхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401015



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 4/11

Баянхошуу

Засаг даргын Тамгын Газрын түлш, шатахууны
тендер зохион байгуулах үнэлгээний
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн хөрөнгөөр 2024 онд түлш, шатах, тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга Б.Анхбаяр (Санхүүгийн албаны дарга)

Гишүүд Ц. Ариунаа (Иргэний төлөөлөл)

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга М. Отгонадалай (Соёл, Сан хариуцсан нягтлан бодогч)


2. Үнэлгээний хороонд ДААЛГАХ НЬ:

А)Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу 2024 оны 02 дугаар сарын26 -ны дотор зохион байгуулсугай.

Б)Тендер шалгаруулалтын талаарх мэдээллийг аж ахуй нэгж байгууллагуудад хүргэж ил тод, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтлан явуулахыг үүрэг болгосугай.

В)Тендер шалгаруулалтаар бараа нийлүүлэх эрх авсан аж ахуй нэгжтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Ж. Алтантуяа)-д даалгасугай.

ДАРГА



А. БАТБАЯР

642401017



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/р

Баянхошуу

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улаанбаатар хотод зохион байгуулах сар шинийн нутгийн нэгдсэн золголтын арга хэмжээнд 5.000.000 (Таван сая) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардлагатай санхүүжилтийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (М.Отгондалай)-д зөвшөөрсүгэй.

3. Нэгдсэн золголтын бэлтгэл ажлыг сайтар хангаж, зохион байгуулалттай, ёслол төгөлдөр хийж гүйцэтгэхийг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

842401019



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/13

Баянхошуу

Цас зудын нөхцөл байдалтай холбоотой
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.1.12, 59.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32.1.1, 32.1.9, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөцөөс хөрөнгийн зохицуулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч тус сумын хэмжээнд нийт нутгаар хатуу цасан бүрхүүл тогтож цасны зузаан тал газраа 15-25 см, жалга гуунд 45-70 см, түлээ түлшгүй болж байгаа өрхийн тоо нэмэгдэж байна, хаагдсан зам даваа нэлээд хэрэгтэй байгаа зэргийг харгалзан “Илгээлтийн эзэн-2024” аян зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, байгууллага, багуудаас оролцуулах илгээлтийн эздийн тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Түлээ түлш шаардлагатай, хүн хүчний дэмжлэг зайлшгүй шаардлагатай, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, 0-5 насны хүүхэдтэй өрхүүдийн судалгааг үнэн бодитоор гаргаж ирүүлэхийг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.“Илгээлтийн эзэн-2024” аяны арга хэмжээнд болон зам даваа засах зэрэг шаардлагатай арга хэмжээнд зарцуулах зардалд 10.000.000 (Арван сая) төгрөг зарцуулахыг няглан бодогч (М.Отгондалай)-д зөвшөөрсүгэй.

4.Аяны удирдамжтай танилцаж шаардагдах хүн хүчний дэмжлэг үзүүлж, ажилтнуудын ажлыг зохицуулж хамтарч ажиллахыг байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401021

Сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/15 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

“Илгээлтийн эзэн-2024” аяны тухай

2024 оны 02 дугаар сарын 22

Баянхошуу

Аяны зорилго: Тус сумын хэмжээнд цас, зудын байдал маш хүндрэлтэй нөхцөл байдалд хүрч монгол түмний аж, амьдралын үндэс болсон мал сүрэг ихээхэн хорогдож, нүүдэл хийх, мал тэжээх зэргээр малчид нэлээд ядарч хүч мөсдөж байгаа учир малчдад хүн хүчний дэмжлэг үзүүлж Мал төрийн хамгаалалтад байх үндсэн хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэх зорилгоор уг аяныг зохион байгуулж байна.

Зохион байгуулах хугацаа: 2024 оны 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 06-ны өдрийг дуустал

Хийж гүйцэтгэх ажил:

- 1.Тухайн малчин өрхийн гишүүний адил өрхийн бүхий л ажилд туслана.
- 2.Нүүдэл хийх, малд явах, мал тэжээх зэрэгт идэвх санаачилгатай байх.
- 3.Хийж гүйцэтгэж буй ажлаа зургаар баримтжуулж авах
- 4.10 хоног ажилласан тайланг бичиж Засаг даргын Тамгын газарт ирүүлэх

Илгээлтийн эздийг хуваарилах малчин өрхүүдэд тавигдах шаардлага:

- 1.Ахмад настан өрх
- 2.Эрүүл мэндийн байдал хүнд хүнтэй
- 3.0-5 насны хүүхэдтэй
- 4.Зайлшгүй шаардлагаар хөдөө ганц биеэрээ яваа

Талуудын үүрэг:

Засаг даргын Тамгын газрын үүрэг:

- 1."Илгээлтийн эзэн-2024"-аянд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх
- 2.Аянд оролцогчдыг малчин өрхүүдэд хүргэх ажлыг зохион байгуулах
- 3.Илгээлтийн эздэд ХАБЭАхуйн талаар заавар зөвлөмж өгч аливаа эрсдлээс өөрсдийгөө хамгаалах анхан шатны мэдээллийг өгч аюулгүй байдлыг хангуулж явуулах

Байгууллагуудын үүрэг:

- 1.Сумын Засаг даргын Захирамжийн хэрэгжилтийг хангаж хуваарилсан тооны хүнс хүчийг заасан хугацаанд бэлэн байлгах
- 2.Эзгүй байгаа ажилтнуудын ажил үүргийн хуваарьт зохицуулалт хийж төрийн үйлчилгээг тасралтгүй явуулахад анхаарах
- 3.Хөдөлмөр хамгааллын заавар зөвлөмж сайтар өгч, дулаан хувцас бэлтгэл бэлэн байдлыг хангуулах
- 4.Илгээлтээр явах ажилтнуудын биеийн эрүүл мэндэд анхаарч, эрүүл мэндийн үзлэг үйлчилгээнд хамруулж явуулах
- 5.Илгээлтээр явж буй ажилтнуудад цалин урамшууллыг бүрэн тооцож олгох

Илгээлтийн эздийн үүрэг:

1. Хувийн бэлтгэлээ сайтар хангаж хөнжил пүүгээ, дулаан хувцас, малгай, бээлий, солих хувцас зэргээ бүрэн базааж явах
2. Тогтмол хэрэглэдэг эм тариа байдаг бол бэлтгэл хангаж явах
3. Очсон айлдаа өрхийн нэгэн гишүүний адилаар өөриймсөг байж, өрхийн бүхий л ажилд чин сэтгэлээсээ туслаж хамтарч ажиллах
4. Хийж гүйцэтгэж буй ажлаа баримтжуулан тайлан бичиж өгөх
5. Өдөр бүр харьяа байгууллагатайгаа холбогдож мэдээлэл дамжуулж байх

Олгох цалин, урамшуулал: Төрийн албан хаагчдад харьяа байгууллагаас цалин хөлсийг олгоно, томилолтын зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөр журмын дагуу орон нутагт 1 өдөр 14 мянган төгрөгөөр тооцон олгоно.

Илгээлтийн эзэн иргэдийн хувьд өдрийн 30,000 төгрөгөөр тооцон 10 хоногийн ажлын хөлсийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгоно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН,
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Ж.АЛТАНТУЯА
Ж.АЛТАНТУЯА

Сумын Засаг даргын 2024 оны 2 дугаар
сарын 22-ны өдрийн 1/12 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



БАЙГУУЛЛАГА, БАГУУДААС ОРОЛЦУУЛАХ
ИЛГЭЭЛТИЙН ЭЗДИЙН ХУВААРЬ

№	Байгууллага, багийн нэр	Хуваарьт тоо
1	Засаг даргын Тамгын газар	8
2	Ерөнхий боловсролын сургууль	5
3	Цэцэрлэг	3
4	Эрүүл мэндийн төв	2
5	Бага сургууль	3
6	Соёлын төв	2
7	Цаг уур	2
8	Хайрхан 1-р баг	2
9	Сүмбэр 2-р баг	2
10	Үнэгт 3-р баг	2
11	Баяннуур 4-р баг	2
12	Мандал 5-р баг	3
13	Баянхошуу 6-р баг	4
	Нийт	36



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1/14

Баянхошуу

┌ Асран хамгаалагч тогтоох тухай ─┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэр бүлийн тухай хуулийн 64.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын Хайрхан 1 дүгээр багийн иргэн Т.Түвшинбаяр, Т.Түвшинтөр нарыг өсгөж байсан аав Бат-Очирын Түмэнбаяр нь 2024 оны 02 дугаар сарын 18-нд нас барж Т.Түвшинбаяр, Т.Түвшинтөр нар нь бүтэн өнчин үлдсэн тул 18 насанд хүртэл эгч Түмэнбаярын Учралтзаяаг асран хамгаалагчаар тогтоосугай.

2.Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлж ажиллахыг (Т.Учралтзаяа)-д даалгасугай.

3.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ж.Ганчулуун), Хайрхан 1 дүгээр багийн Засаг дарга (Г.Мөнхбаясгалан) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТБАЯР



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 4/15

Баянхошуу

Газар өмчлөх захирамжийн хавсралтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар өмчлөх эрхийн гэрчилгээг шинэчлэн авах хүсэлтээ ирүүлсэн Баянхошуу 6 дугаар багийн иргэн Бямба овогтой Алтансүх-д газрын хэмжээ, газрын байршлын хаяг, нэгж талбарын дугаарыг хавсралтад зааснаар тус тус шинэчлэн тогтоож шийдвэрлэсүгэй.

2.Иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрыг өмчлөх эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (А.Түмэннаст)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401027

Сумын Засаг даргын *А.Б.А.* оны *20* дугаар сарын
23-ны өдрийн *А/Б* дугаар захирамжийн хавсралт



ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

№	Газар өмчлөгчийн		Өмнөх захирамжийн			Өмнөх захирамжийн нэгж талбарын мэдээлэл		Шинээр үүссэн нэгж талбарын мэдээлэл			
	Овог нэр	Регистрийн дугаар	Огноо	дугаар	Хавсралтын мөрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Хаяг	Талбарын хэмжээ м ²	Нэгж талбарын дугаар	Хаяг	Талбарын хэмжээ м ²
1.	Бямба Алтансүх	ВП76021219	2012.02.20	15	9	6411000074	Баянхошуу 6 дугаар баг, Мянгат 3-р хороо, 1-17 тоот	721	6411002176	Баянхошуу 6 дугаар баг, Мянгат 3, 311 тоот	810

.....000.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/16

Баянхошуу

**Орон тооны бус зөвлөлийг татан
буулгах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 49 дүгээр зүйлийн 49.3.4, Нийгмийн даатгалын багц хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын дагуу ажиллаж байсан сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан орон тооны бус зөвлөлийг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны А/25 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТБАЯР

642401029



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 4/17

Баянхошуу

**Газар эзэмших эрхээ бусдад
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Үнэгт 3 дугаар багийн иргэн Лхаебум овогтой Агваантогтох өвөлжөөний доорхи газрын газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 334 тоот гэрээ, иргэн Балжинням овогтой Мөнхтогоогийн газар эзэмших эрхийг шилжүүлэн авах хүсэлтийг тус тус шийдвэрлэн эзэмшүүлсүгэй.

2. Шилжүүлэн эзэмшүүлэх газрын байршил, хаяг, газрын хэмжээ, нэгж талбарын дугаарыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

3. Газрын улсын бүртгэлд бүртгэж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг газрын даамал (А.Түмэннаст)-д даалгасугай.

4. Энэ захирамжийг гарсантай холбогдуулан газрын кадастрын мэдээллийн сангийн улсын бүртгэлийн 06434-2019/00186 дугаартай газар эзэмших эрхийн гэрээг хүчингүй болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батболд)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБАЯР

842401031



Сумын Засаг даргын *А.Оюу* оны *02* дугаар сарын *24*-ны өдрийн *А.А.А.* дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХЭЭ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

Газар эзэмших эрх шилжүүлэгчийн овог, нэр, газрын мэдээлэл		Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр, газрын мэдээлэл						Газрын хаяг	Оргихын дуганцаг						
№	Овог	Нэр	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м ²	Газрын зориулалт	Эцэг эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Эзэмших Газрын эрхийн төрөл	Өвөлжөөний дорхи газар	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м ²	Газар эзэмших хугацаа /жил/	Үнэт з дугаар бар	Газрын байршил
1	Лхаебум	Агваантогтох	6411001770	700	Өвөлжөөний дорхи газар	Балжинням	Мөнхтоого	ВК74101017	Эзэмших	Өвөлжөөний дорхи газар	6411001770	700	30	Үнэт з дугаар бар	Газрын байршил

.....оОо.....



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/18

Баянхошуу

Үзлэг шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.12, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй дулааны үйлдвэрлэл эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Д.Батболд (Засаг даргын орлогч)

Гишүүд

Ж.Ганчулуун (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

М.Мандах (Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Мөнхсайхан (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

О.Нэмэхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

2.Эко дулаан ХХК болон нам даралтын зуухтай айл өрх, аж ахуйн нэгжийн дулаан үйлдвэрлэлийн нөхцөл байдал, аюулгүй ажиллагаа зэрэгт үзлэг шалгалт хийж холбогдох, дүрэм журам, норм стандартыг ханган ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, бодит нөхцөл байдлыг илтгэх хуудсаар танилцуулж, шаардлагатай асуудлыг мэргэжлийн байгууллагад уламжлан аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг ажлын хэсэг (Д.Батболд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ж.Алтантуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАТБАЯР



642401035